



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/125/НА-СТА-ТХН

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2025 он

Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.mn](mailto:naranchimegts@audit.mn)

Аудитын менежер: П.Чанцалдулам

Утас: 260512 Цахим хаяг: [chantsaldulam.p@audit.mn](mailto:chantsaldulam.p@audit.mn)

Аудитор: О.Наранбат

Утас: 261740 Цахим хаяг: [naranbato@audit.mn](mailto:naranbato@audit.mn)

Гэрээгээр гүйцэтгэсэн: “Конфиденсе Аудит” ХХК-ийн

Захирал П.Ариунаа

Утас: 99994990 Цахим хаяг: [info@confidenceaudit.mn](mailto:info@confidenceaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.13 № 07/367  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд 2020 оны 5 дугаар сард байгуулсан МОН9204 дугаартай буцалтгүй тусламжийн гэрээнд тусгагдсан ажлууд бүрэн хэрэгжиж Гэр хорооллын нийтийн тээврийг сайжруулах төсөл нь үйл ажиллагаагаа 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдөр дуусгавар болгосон.

Төсөл нь 1 дүгээр зорилтын хүрээнд 3,156,670.6 мянган төгрөг, 2 дугаар зорилтын хүрээнд 2,938,312.1 мянган төгрөг, төслийн багийн зардалд 571,103.9 мянган төгрөг, нийт 6,666,086.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тусламжийн гэрээнд заасны дагуу Монгол улсын засгийн газар нь төслийн зорилтын хүрээнд барилгын ажлын гүйцэтгэгч болон тоног төхөөрөмж нийлүүлсэн компаниудад нийт 500,241.3 мянган төгрөгийн НӨАТ-ын хөнгөлөлт үзүүлж гэрээний үүргээ биелүүлсэн байна.

Төслийн хэрэгжүүлэгч байгууллага болох Нийслэлийн засаг даргын тамгын газар нь төслийн удирдлагын гарын авлагад заасны дагуу төслийн хэрэгжилтэд оролцох ажилтнуудын цалин, олон нийт оршин суугчидтай хийх уулзалт, бичиг хэргийн материал, төслийн нэгжийн оффисын байрны түрээсийн төлбөр зэрэгт нийт 307,187.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

МОН-9204 дугаартай буцалтгүй тусламжийн гэрээнд Ядуурлыг бууруулах Японы сан нь 2,000.0 мянган ам.долларын буцалтгүй тусламжийг олгохоор заасан боловч төслийн удирдлага 1,980.0 мянган ам.долларын тусламжийг зарцуулж 20.0 мянган ам.долларын тусламжийг ашиглалгүй буцаасан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Төслийг хэрэгжүүлэгч НЗДТГ нь төслийн төрийн сангийн дансад үлдсэн 1.9 мянган ам.долларыг АХБ-руу буцаан төвлөрүүлээгүй, төслийн барьж байгуулсан хөрөнгийг хүлээн авах байгууллагад шилжүүлээгүйгээс аудитаар дуусгалтын балансыг баталгаажуулаагүй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,293,518,703.14</b>	<b>6,601,997,823.96</b>
31	<b>МӨНГӨН БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	314,011,491.15	6,773,736.72
3121	Банканд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	35,578,107.65	-
3122	Банканд байгаа бэлэн мөнгө /гадаад валютаар/	278,433,383.50	6,773,736.72
36	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>4,979,507,211.99</b>	<b>6,595,224,087.24</b>
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	4,979,507,211.99	6,595,224,087.24
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,293,518,703.14</b>	<b>6,601,997,823.96</b>
4	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	239,091,091.47	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	10,000.64	-
4144	Урьдчилж орсон орлого	239,081,090.83	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,054,427,611.67</b>	<b>6,601,997,823.96</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	5,054,427,611.67	6,601,997,823.96
512	Хуримтлагдсан үр дүн	5,054,427,611.67	6,601,997,823.96
51210	Өмнөх үеийн үр дүн	2,197,187,802.67	5,054,427,611.67
51220	Тайлант үеийн үр дүн	2,857,239,809.00	1,547,570,212.29
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,293,518,703.14</b>	<b>6,601,997,823.96</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>3,112,424,206.80</b>	<b>1,773,379,627.51</b>
120	Бусад орлого	600,000.00	4,551,726.00
122	Тусламжийн орлого	2,767,387,782.11	1,544,876,337.25
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутаг/	113,209,886.14	119,499,619.36
145006	НӨАТ-ын хөнгөлөлт Засгийн газрын санхүүжилт	231,226,538.55	104,451,944.90
2	<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>294,536,705.89</b>	<b>226,568,917.36</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>294,536,705.89</b>	<b>226,568,917.36</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>294,536,705.89</b>	<b>226,568,917.36</b>
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	126,314,305.00	95,863,731.00
21010	Цалин	126,314,305.00	95,863,731.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,789,289.00	11,205,567.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>39,223,225.75</b>	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	39,136,380.00	-
210808	Банк санхүүгийн байгууллагын хураамж	86,845.75	-
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,209,886.14	<b>119,499,619.36</b>
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	113,209,886.14	119,499,619.36
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>2,817,887,500.91</b>	<b>1,546,810,710.15</b>
145	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>52,616,333.07</b>	<b>759,502.14</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	52,616,333.07	759,502.14
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>13,264,024.98</b>	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	13,264,024.98	-
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	<b>39,352,308.09</b>	<b>759,502.14</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>2,857,239,809.00</b>	<b>1,547,570,212.29</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,421,495,369.42</b>	<b>844,010,221.07</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,421,495,369.42	844,010,221.07
120	Нийтлэг татварын бус орлого	1,835,085.00	4,960,456.00
120009	Бусад орлого	1,835,085.00	-
122	Тусламжийн орлого	1,419,660,284.42	839,049,765.07
122002	Хандив тусламж /гадаад/	1,419,660,284.42	839,049,765.07
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>182,465,058.36</b>	<b>107,488,028.64</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>182,465,058.36</b>	<b>107,488,028.64</b>
<b>210</b>	<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>182,465,058.36</b>	<b>107,488,028.64</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>127,720,890.27</b>	<b>94,796,428.64</b>
210101	Үндсэн цалин	127,720,890.27	94,796,428.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,607,788.09	12,691,600.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	14,120,988.09	9,111,700.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	371,700.00	895,000.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	297,360.00	447,500.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	74,340.00	447,500.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	743,400.00	1,789,900.00
<b>2108</b>	<b>БУСДААР ГҮЙЦЭТГҮҮЛСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР, ХУРААМЖ</b>	<b>39,136,380.00</b>	<b>-</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	39,136,380.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,239,030,311.06</b>	<b>736,522,192.43</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>2,284,666,325.00</b>	<b>1,044,519,449.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,284,666,325.00</b>	<b>1,044,519,449.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,284,666,325.00</b>	<b>1,044,519,449.00</b>
223001	Бусад хөрөнгө	2,284,666,325.00	1,044,519,449.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(2,284,666,325.00)</b>	<b>(1,044,519,449.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
14	Бусад эх үүсвэр	-	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	759,502.14
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	13,164,024.98	-
<b>8</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(13,164,024.98)</b>	<b>759,502.14</b>
<b>9</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(1,058,800,038.92)</b>	<b>(307,237,754.43)</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,372,811,530.07</b>	<b>314,011,491.15</b>
<b>11</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>314,011,491.15</b>	<b>6,773,736.72</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	-	-	<b>2,197,187,802.67</b>	<b>2,197,187,802.67</b>
2	Тайлант үеийн үр дүн	-	-	2,857,239,809.00	2,857,239,809.00
3	<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	-	-	<b>5,054,427,611.67</b>	<b>5,054,427,611.67</b>
4	Тайлант үеийн үр дүн	-	-	1,547,570,212.29	1,547,570,212.29
5	<b>2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	-	-	<b>6,601,997,823.96</b>	<b>6,601,997,823.96</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	<b>1,761,809,000.00</b>	<b>1,152,007,477.64</b>	<b>609,801,522.36</b>	65.4
<b>Урсгал зардал</b>	<b>120,603,200.00</b>	<b>107,488,028.64</b>	<b>13,115,171.36</b>	89.1
<b>Бараа, ажил үйлчилгээний зардал</b>	<b>120,603,200.00</b>	<b>107,488,028.64</b>	<b>13,115,171.36</b>	89.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	107,196,000.00	94,796,428.64	12,399,571.36	<b>88.4</b>
Үндсэн цалин	107,196,000.00	94,796,428.64	12,399,571.36	88.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,407,200.00	12,691,600.00	715,600.00	94.7
Тэтгэвэрийн даатгал	9,111,700.00	9,111,700.00	-	100.0
Тэтгэмжийн даатгалын	1,072,000.00	895,000.00	177,000.00	83.5
ҮОМШӨ-ний даатгал	536,000.00	447,500.00	88,500.00	83.5
Ажилгүйдлийн даатгал	543,600.00	447,500.00	96,100.00	82.3
Эрүүл мэндийн даатгал	2,143,900.00	1,789,900.00	354,000.00	83.5
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,641,205,800.00</b>	<b>1,044,519,449.00</b>	<b>596,686,351.00</b>	63.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,641,205,800.00	1,044,519,449.00	596,686,351.00	63.6
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,641,205,800.00</b>	<b>844,769,723.21</b>	<b>796,436,076.79</b>	51.5
Бусад хөрөнгө	1,641,205,800.00	839,049,765.07	802,156,034.93	51.1
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,641,205,800.00</b>	<b>839,049,765.07</b>	<b>802,156,034.93</b>	51.1
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	1,641,205,800.00	839,049,765.07	802,156,034.93	51.1
Хандив тусламж гадаад		759,502.14		
Бусад эх үүсвэрийн орлого		4,960,456.00		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		314,011,491.15		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		6,773,736.72		
АЖИЛЛАГСДЫН ТОО		3	3	-
Удирдах ажилтан		1	1	-
Гүйцэтгэх ажилтан		2	2	-

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитын асуудлаар 1 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

#### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Валютын харилцах дансанд ашиглаагүй үлдсэн 1.9 мянган ам.долларыг АХБ руу буцаан төвлөрүүлээгүй, барьж байгуулсан автобусны буудлууд, замын камержуулалт, хяналтын тоног төхөөрөмжүүдийг ашиглах байгууллагуудад нь хүлээлгэн өгөөгүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>